

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн	6
2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	6
2.8.2 Авлага.....	6
2.8.3. Бараа материал	7
2.8.4 Үндсэн хөрөнгө	7
2.8.5 Өр төлбөр	8
2.8.6 Засгийн газрын хувь оролцоо	8
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.12. Шилэн дансны мэдээлэл	10
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3. Менежментийн захидал	11
3.1 Биет хөрөнгийн данстай холбоотой асуудал.....	11
3.2 Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал	12
3.3 Орлогын данстай холбоотой асуудал	12
3.4 Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал	12
3.5 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал	13
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин
мкв	метр квадрат



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Э.БАТБАЯР ТАНАА

2020.04.24 № 1329
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагат мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагч Э.Батбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн хөрөнгийн ангилал, ашиглах жилийг тогтоон, бүртгэлийг үнэн зөв хөтлөх, өөрийн орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөх, санхүүгийн тайлангийн иж бүрдлийг хангах, шилэн дансанд мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд байршуулж байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 06-наас 2020 оны 4 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор Ц.Энхжаргал гүйцэтгэв.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 01/376 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангахад оршино.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн үндсэн чиг үүргийг шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд арга зүй, мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангах гэж тодорхойлсон байна. Дээрх чиг үүргээс гадна шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах ажлыг нэгтгэн зохион байгуулах, шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах, шүүгчийг хуульчдаас шилж олох, шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүхийн хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Тайлант онд шүүхийн хөгжлийн стратегийг тодорхойлох, шүүхийн шинэтгэлийн ололтыг бататгах, бэхжүүлэх, хамгаалах, хөгжүүлэх чиглэлд анхаарлаа төвлөрүүлэх, судалгаа мэдээлэл дээр тулгуурлаж бодлого шийдэл гаргах, Шүүхийн тухай багц хуульд үр нөлөөний судалгаа хийж, боловсронгуй болгох, шүүхийг цахимжуулах, шүүхийн үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх зорилтын хүрээнд 98 хөтөлбөр, 333 арга хэмжээ төлөвлөснөөс 78.3 хувийн хэрэгжилттэй байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2015 оны 106 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжийн өөрчлөлтийг нэмж тусгах шаардлагатай байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дотоод аудитын газар нь 2019 онд харьяа орон нутаг дахь 8 шүүхийн тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 88.6 сая төгрөгийн 57 зөрчлийг илрүүлснээс 50.6 сая төгрөгийн 29 алдааг залруулж, 38.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 28 зөвлөмжийг өгсөн байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 52,825.9 сая төгрөгийн 2.0 хувь буюу 1,056.5 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд дахин өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

2.8. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 1.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	1.1	0.0	-1.1
Төгрөг	1.1	0.0	-1.1
Төрийн сан	1.1	0.0	-1.1
Дүн	1.1	0.0	-1.1

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Тайлант онд төрийн сангийн эхний үлдэгдэл 1.1 сая төгрөгийг улсын төсвийн зарлагыг санхүүжүүлэхэд зарцуулсан байна.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой 160.7 сая төгрөгийн зөрчлийг илрүүлсэн байна. Тухайлбал,

- Говь-Алтай аймаг дахь шүүхийн тамгын газар: худалдан авах ажил зохион байгуулаагүйгээр 20.5 сая төгрөгийн бараа материал худалдан авсан, цалингийн зардлаас нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, ажилчдад 7.8 сая төгрөгийн урамшууллыг илүү олгосон, зэрэг дэв болон ажилласан жилийн нэмэгдэл, хоолны мөнгийг зөрүүтэй тооцоолсон, шатахуун зарцуулалтын тооцоо бодоогүй,
- Дорнод аймаг дахь шүүхийн тамгын газар: Цахим төлбөрийн баримтгүйгээр 63.8 сая төгрөгийн худалдан авалт хийсэн,
- Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар: 24.5 сая төгрөгийн шатахуун, хангамжийн материалыг харьцуулалтын арга хэрэглээгүйгээр шууд худалдан авсан,
- Төв аймаг дахь шүүхийн тамгын газар: 19.8 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгосноос гадна шагналыг давхардуулан олгосон,
- Дархан-Уул аймаг дахь Анхан шатны шүүхийн тамгын газар: Цалингийн зардлаас 7.7 сая төгрөгийн шагнал олгосон,
- Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар: Зарим ажилтнуудад 7.1 сая төгрөгийн ээлжийн амралтын олговор, тэтгэмж, цалин хөлсийг давхардуулан олгосон, нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу тооцоолсон,
- Баянхонгор аймаг дахь шүүхийн тамгын газар: нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 6.3 сая төгрөгийг цалинд олгосон байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 5.8 сая төгрөг болж, өмнөх оноос 75.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2.9	1.0	-1.9
Татаас, санхүүжилтийн авлага	0.1	0.0	-0.1
Бусад авлага	21.0	4.8	-16.2
Дүн	24.0	5.8	-18.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	24.0	5.8	-18.2
Дүн	24.0	5.8	-18.2

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Авлагын дансанд ажиллагчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой 3.7 сая, байр ашиглалттай холбоотой 2.1 сая төгрөгийн үлдэгдэл байна.

2.8.3. Бараа материал

Тайлант онд бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 1,150.2 сая төгрөг болж, өмнөх оноос 60.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн бараа материал	1,089.8	1,150.2	60.4
Дүн	1,089.8	1,150.2	60.4
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	1,089.8	1,150.2	60.4
Дүн	1,089.8	1,150.2	60.4

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь аж ахуй, бусад хангамжийн материал худалдан авсантай холбоотой байна.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын данстай холбоотой 100.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал,

- Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар: 34.5 сая төгрөгийн бараа материал хүлээлцсэн акт үйлдээгүй, худалдан авах гэрээ дүгнээгүй,
- Дорноговь аймгийн Замын-Үүд суман дахь Сум дундын шүүхийн тамгын газар, Завхан аймгийн Тосонцэнгэл суман дахь Сум дундын шүүхийн тамгын газар: 1.8 сая төгрөгийн бараа материалыг буруу ангилан бүртгэсэн, зориулалт бусаар зарцуулсан байна.

2.8.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 1,334.6 сая төгрөг буюу 2.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Үндсэн хөрөнгө	49,356.3	48,021.7	-1,334.6
Биет хөрөнгө	44,671.3	43,300.9	-1,370.4
Биет бус хөрөнгө	4,685.0	4,720.8	35.8
Дүн	49,356.3	48,021.7	-1,334.6
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	49,356.3	48,021.7	-1,334.6
Дүн	49,356.3	48,021.7	-1,334.6

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 797.2 сая, төсвийн хөрөнгөөр 1,594.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хандиваар 8.3 сая, балансаас баланст 1,215.6 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна. Мөн 218.1 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 556.3 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн байна.

Дуусаагүй барилга дансанд Хан-Уул дүүрэг дэх шүүхийн цогцолбор барилгын суурийн газар шороо болон зорийн давхрын угсралтын нийт 5,008.5 сая төгрөгийн ажлыг бүртгэсэн байна.

Төсвийн шууд захирагчийн аудитаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой 37.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- *Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар: 28.6 сая төгрөгийн хөрөнгөд тооллого хийгээгүй,*
- *Дархан-Уул аймаг дахь Давж заалдах шатны шүүхийн тамгын газар: Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.*

2.8.5 Өр төлбөр

Тайлант онд богино хугацаат өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 0.9 сая төгрөг болж, өмнөх оноос 3.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр	4.5	0.9	-3.6
Нийт дүн	4.5	0.9	-3.6
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	4.5	0.9	-3.6
ДҮН	4.5	0.9	-3.6

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн дансанд ажиллагчидтай холбоотой цалингийн өглөгийг бүртгэсэн байна.

2.8.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 49,176.8 сая төгрөг болж, өмнөх оноос 1,290.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6 Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/
Засгийн газрын хувь оролцоо	50,467.6	49,176.8	-1,290.7
Дүн	50,467.6	49,176.8	-1,290.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	50,467.6	49,176.8	-1,290.7
Дүн	50,467.6	49,176.8	-1,290.7

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсан нь тайлант онд 3,212.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлсөн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан урсгал зардалд 50,272.7 сая, хөрөнгийн зардалд 800.0 сая, нийт 51,072.7 сая төгрөгийн төсвийг баталжээ.

Тайлант онд 51,012.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 60.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүжилтийг бүрэн авч, өөрийн үйл ажиллагааны орлогоос 77.4 сая төгрөг нийт 51,090.1 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлжээ. Үүнээс урсгал зардалд 49,784.0 сая, хөрөнгийн зардалд 797.2 сая төгрөгийг зарцуулж 508.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардал 50,581.2 сая төгрөг буюу 99.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 491.5 сая төгрөг байгаа нь бараа үйлчилгээний зардлыг 480.6 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, ерөнхийлөгчийн зарлигаар 12 шүүгчийн эрх түдгэлзсэн, шүүхийн ерөнхий зөвлөлийн 2 гишүүнийг нөхөн томилоогүйтэй холбоотойгоор цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 404.7 сая, анхан болон давж заалдах шатны шүүх хуралдааны зардал болох шинжээч, орчуулагч, хэлмэрч, гэрч, хохирогчийн зардал 27.3 сая, төлөвлөж байсан сургалт хойшлогдсоноос 7.7 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна. Мөн интернэтийг нэгдсэн байдлаар тендер зарлаж шийдвэрлэн 13.1 сая, халаалтыг намар 15 хоногийн дараа авч, хавар 15 хоногийн өмнө хаасантай холбоотойгоор 15.1 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар 34.6 сая, засаг даргын нөөц хөрөнгөөс 99.7 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 233.1 сая, нийт 367.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 316.9 сая, урсгал шилжүүлэгт 49.7 сая, нийт 366.6 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 0.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа ажлын алба, 41 шүүхийн тамгын газар, 1 төвлөрсөн данс нийт 43 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 40 байгууллага, данс аудитад хамрагдан, 3 байгууллагад итгэл үзүүлсэн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас ажлын алба, төвлөрсөн данс, 3 шүүхийн тамгын газрын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, 35 байгууллагад “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,418.1 сая төгрөгийн 77 алдаа, зөрчил илрүүлснээс 623.3 сая төгрөгийн 16 алдааг залруулж, 21.1 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 96.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 9 албан шаардлага хүргүүлэн, 676.8 сая төгрөгийн зөрчилд 42 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангийн зарим үзүүлэлтүүдийг зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд: Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийн орлого 91.8 сая, мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал 2.0 сая, нийт 93.8 сая төгрөгийг тус тус илүү нэгтгэснийг залруулан бүртгэсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 446.4 сая төгрөгийн 1 алдаа, 50.0 сая төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудит

Аудитад хамрагдсан 40 төсвийн шууд захирагчаас 35 шүүхийн тамгын газрын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгч, шүүхийн төвлөрсөн төсөв, ажлын алба, 3 шүүхийн тамгын газрын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан.

Аудитаар нийт 827.9 сая төгрөгийн 70 алдаа, зөрчил илрүүлснээс 529.5 сая төгрөгийн 14 алдааг залруулж, 21.1 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 96.9 сая төгрөгийн

алдаа, зөрчлийг арилгах 9 албан шаардлага хүргүүлэн, 180.4 сая төгрөгийн зөрчилд 37 зөвлөмжийг өгсөн.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант онд хэрэгжүүлсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн аудит хийж байгаа тул аудитад хамруулаагүй болно.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэгчээр Барилгын тухай хуулиар тогтоосон зүгшрүүлэх, тохируулах хугацааг баримталж, барилгын чанарын баталгааг хангуулж ажиллах шаардлагатай байна.

Шүүхийн ерөнхий зөвлөл нь Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 9 дүгээр тогтоолоор 4,964.4 сая төгрөгийн балансын үнэ бүхий дуусаагүй барилга байгууламжийг шилжүүлж авсан байна. Хан-Уул дүүрэгт байрлалтай дуусаагүй барилгын суурин дээр 10 давхар шүүхийн цогцолбор бариулахаар төлөвлөжээ. Тус барилгын суурийн газар шорооны ажил, зорийн В2 давхрын барилга угсралтын ажлыг 2013-2014 онд хийсэн байна. Ажлын гүйцэтгэлийг 2019 онд Барилгын төсөвчдийн холбоо төрийн бус байгууллагаар хянуулахад бодит гүйцэтгэл 1,036.5 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлжээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 3252 мэдээллийг хугацаандаа байршуулж, 7 мэдээллийг байршуулаагүй, 268 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд нь бүрэн байршуулах талаар зөвлөмж хүргүүлсэн болно.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 22.2 сая төгрөгийн 14 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулж, 31.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 8 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Нийт 27 зөвлөмж өгснөөс 23 зөвлөмжийг хэрэгжүүлж, 4 зөвлөмж хэрэгжих шатандаа буюу зөвлөмжийн хэрэгжилт 85.2 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулаагүй 794.8 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 1,056.5 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул “Зөрчилгүй” дүгнэлтийг өгч байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмж цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Биет хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Биет хөрөнгийн дансанд үндсэн хөрөнгийг зохисгүй ангилан бүртгэсэн, ижил төстэй шинж чанартай хөрөнгийн ашиглах жилийг ялгаатай байдлаар тогтоон бүртгэлд тусгасан байна. Үүнд:

- 12 шүүхийн тамгын газар барилга байгууламж дансанд бут сөөг, нийтийн эзэмшлийн 359.4 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн,
- 5 шүүхийн тамгын газар бусад үндсэн хөрөнгө дансанд машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын шинж чанартай 87.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн,
- Ижил төстэй хөрөнгийн ашиглах жилийг харилцан адилгүй хугацаагаар тогтоосон. Тухайлбал, авто зогсоолыг 5-21 жилээр, төмөр хашааг 4-25 жилээр, явган замыг 0-21 жилээр элэгдүүлэн зардалд бүртгэсэн байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", УСНББОУС 17" Үндсэн хөрөнгө"-ийн Элэгдүүлэх дүн ба элэгдүүлэх хугацаа 67-д "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянах ёстой ..." гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, ангилал болон ойлгомжтой байх, үнэн зөв байх болон үнэлгээ батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Хөрөнгө үнэгүйдэх, үрэгдэх, санхүүгийн тайланд үлдэх өртөг буруу илэрхийлэгдэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн ангиллыг залруулах, ашиглалтын хугацааг хянаж, элэгдлийн зардлыг үнэн зөв тооцоолж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Биет бус хөрөнгийн дансны дэлгэрэнгүй бүртгэлийг газрын гэрчилгээ, кадастрын зурагтай тулган шалгахад дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Төв аймгийн шүүхийн тамгын газар төрийн захиргааны байгууллагын зориулалт бүхий 50.0 сая төгрөгийн үнэлгээ бүхий 2000 мкв газрыг бүртгээгүй орхигдуулсан,
- 3 шүүхийн тамгын газар газрын эзэмших зориулалтыг, 9 шүүхийн тамгын газар газрын талбайн хэмжээг зөрүүтэй бүртгэсэн байна.

